



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/554

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны Бүтээлч Өвөрхангай-2020 хөтөлбөр”-ийн 3.6.1.2, 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.5.3, 2018 оны аймгийн “2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн ахмад настнуудын туулсан амьдрал, мэдлэг туршлагыг залуучуудад түгээн дэлгэрүүлэх, тэднийг нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах зорилгоор 1000 ахмадын чуулга, уулзалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээний зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 9036000 (есөн сая гучин зургаа мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Чуулга уулзалтын бэлтгэл, зохион байгуулалтыг сайтар ханган ажиллахыг ажлын хэсэг (Б.Сайнжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101008

Аймгийн Засаг даргын 2019... оны 09
дугаар сарын 06...ны өдрийн 1554 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

1000 АХМАДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Б.Сайнжаргал - аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн дэд дарга: Д.Баяртогтох - аймгийн Ахмадын хорооны дарга

Гишүүд: С.Ундрах - аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга

Б.Энхтөр - аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир,
спортын газрын дарга

Д.Шивааннүрдэв - аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл
мэндийн газрын дарга

Ж.Энх-Амар - аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн газрын дарга

Д.Түмэнжаргал - аймгийн Хөгжимт драмын театрын дарга


Н.Баярцэнгэл – аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол,
соёл урлагийн газрын мэргэжилтэн

О.Пүрэвдорж – Арвайхээр сумын Засаг дарга

Х.Дашдэлэг – Тарагт сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Бүзмаа – аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дугаар сарын 06 ны өдрийн 135 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН 1000-Н АХМАДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ Мян.төг	Тайлбар
1	Урлаг, спортын тэмцээний медаль	93 ш	9000	837.0	
2	Шилдэг сумын өргөмжлөл	6 ш	50000	300.0	
3	Спортын тэмцээний батламж	75 ш	1000	75.0	
4	Том баннер	6*4 м	9000	216.0	Тайзны том баннер
5	Жижиг баннер	7.5 м	9000	68.0	
6	Оролцогчдын мандат, дурсгалын зүйлс	1000	6500	6500.0	Аяга энгэрийн тэмдэг, 1000 ахмадын чуулганы зураг багтана.
7	Зохион байгуулагчдын хоолны зардал	40 хүн* 2 өдөр	13000	1040.0	
8	НИЙТ ЗАРДАЛ			9.036.0	